



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/26

Сэлгэгдэлгүй

Үнэлгээний хороо байгуулах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэх "Эрдэнэдалай сумын Хүүхдийн ордны засвар" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Энхдэлгэр (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Үүрцайх (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүдэд: Х.Цэрэн (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)

Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж архивд хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



2823020051